



ХӨДӨЛМӨРИЙН САЙД
Я.САНЖМЯТАВ ТАНАА

**МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА**

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу, Засгийн газрын IV байр,
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

2014.04.29 № 04/38 ЧАТ-САТ/2014/09/СТА-ТНЭЗ

Зөрчил арилгуулах тухай

Хөдөлмөрийн сайдын төсвийн багцын 2013 оны санхүүгийн тайлангийн аудитаар тус байгууллага нь Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2012 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн 4 дүгээр хуралдааны шийдвэрийг үндэслэн Хөдөлмөрийн сайдын 2013 оны А/23 дугаар тушаалаар “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан”-гийн 2013 онд батлагдсан төсвөөс шинээр байгуулагдаж буй Хөдөлмөрийн хэлтсүүдийн хэвийн үйл ажиллагааг хангах, ажиллах нөхцөл байдлыг бүрдүүлэх зорилгоор тоног төхөөрөмж 850.3 сая, тавилга эд хогшил 735.6 сая, автомашин 1,428.0 сая, нийт **3,013.9** сая төгрөгийг зарцуулсан зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д: “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 23 дугаар зүйл 23.3-д: “ХЭДС-гийн хөрөнгийг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанаас өөр зориулалтаар зарцуулахыг хориглоно” гэснийг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т: “аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх...”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2009 оны 47 дугаар тушаалаар батлагдсан “төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 3.1.1-д “.....алдаа зөрчлийг арилгуулахаар төрийн аудитын байгууллага холбогдох албан тушаалтанд албан шаардлага өгнө” гэж заасныг тус тус үндэслэн **Шаардах нь:**

1. Дээрх зөрчлийг таслан зогсоож, сангийн хөрөнгийг холбогдох хууль тогтоомж, зохих заавар, журмын дагуу зарцуулж байх
2. Албан шаардлагаар өгсөн үүргийн биелэлтийг 2014 оны 12 дугаар сарын 01-ний дотор УАГ-т ирүүлэхийг Хөдөлмөрийн яамны ССБТГДарга С.Наранцогт, Ерөнхий нягтлан бодогч Ц.Эрдэнэтөгс нарт хариуцуулав.

АУДИТОР

П.ЧАНЦАЛДУЛАМ

УХА0122